



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А452

Мөрөн сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."г", Төсвийн тухай хуулийн 14.2.3.заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн Засаг дарга Орхон аймаг дах "Медипас" хувийн эмнэлэгтэй гэрээ байгуулан хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад 1,220,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх 1,220,000 (Нэг сая хоёр зуун хорин мянган) төгрөгийг "Эрүүл иргэн-Эрхэм баялаг" дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.



ДАРГА

Л.ГАНБОЛД